



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 07

Номгон

**Шашны байгууллага байгуулах, үйл
ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох журам
баталж, зөвлөл байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох журмыг нэгдүгээр хавсралтаар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн дарга /Э.Цэнд/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг жил бүрийн 12 дугаар сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж байхыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 27 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116175

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 03-ны
өдрийн 07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
ШАШНЫ БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг Баянхонгор аймагт хэрэгжүүлэх, шүтэн бишрэх эрхийнхээ дагуу иргэд сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, үйл ажиллагааны хугацааг сунгахад “Төр сүм хийдийн харилцааны тухай” хуулийн гуравдугаар бүлгийн 9-р зүйлд заасан заалтад нийцүүлэн гаргасан энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Баримт бүрдүүлэх

2.1 Сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авахыг хүссэн иргэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд дараах бичиг баримтыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн бүрдүүлж ирүүлнэ.

2.2 Тухайн сүм, хийд, төв байгуулах шаардлага, үйл ажиллагааны онцлогийг тусгасан өргөдөл

2.3 Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн наймдугаар зүйлийн 2, есдүгээр зүйлийн 3 дахь заалтын шаардлагыг бүрэн хангасан дүрэм

2.4 Шашны байгууллага байгуулахаар санал нэгдсэн хүмүүсийн хурлын шийдвэр, дэлгэрэнгүй тэмдэглэл

2.5 Шашны байгууллага байгуулахыг анх санаачлагчдын товч бүртгэл /овог, нэр, нас, хүйс, боловсрол, мэргэжил, эрхэлж буй ажил, сургууль, гэрийн хаяг, утас/, удирдах гишүүд, ахлагчдын бүртгэл

2.6 Үйл ажиллагаа явуулах ёстойруулга, газрын зөвшөөрөл олгосон гэрчилгээ

2.7 Шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулахад шаардагдах байр танхим барих, худалдан авах, түрээсээр ашиглах үеийн нөхцөл болон холбогдох бусад газраас авсан зөвшөөрөл, гэрээ

2.8 Шашны байгууллагаас шашны зан үйлийг явуулахад шаардагдах ном, судар, бусад хэрэгслийн жагсаалт, хөрөнгө санхүүгийн хэмжээ, эх үүсвэр, тусламж хандив, зардлын тооцоо

2.9 Шашны байгууллагын зарилго, шүтэж итгэдэг номлолын үндсэн үзэл санаа үйл ажиллагааны зарчим, гадаад харилцааг тайлбарласан танилцуулга

2.10 Шашны байгууллагаас бүтэн бишрэгчид, итгэгчдийн дунд зохиох ажлын гол агуулга, чиглэл

2.11 Шашны байгууллагын номлол сургаал айлдагч гадаадын зөвлөх, багшийн дэлгэрэнгүй бүртгэл, фото зураг, гадаадын иргэн харъяатын асуудал эрхлэх албаны болон ажиллаж буй газрын санал зөвшөөрөл, тодорхойлолт

2.12 Тухайн сум, багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагын байршил, лам санзаартан нарын үнэмлэхүй тоог харгалзан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, багийн Засаг даргын өгсөн санал

2.13 Улсын бүртгэлийн газраас нэр давхцсан эсэхийг тодруулж лавлагаа авсан байх

Гурав.Зөвшөөрөл олгох

3.1 Зөвшөөрөл олгохыг хүсэн иргэн энэхүү журмын хоёрдугаар бүлэгт заасан баримт бичгийг бүрдүүлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд өгнө.

3.2 Шашны байгууллага байгуулахыг хүсэж өргөдөл ирүүлсэн иргэдэд Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжуудыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын алба танилцуулж, тодорхой нэгдсэн ойлголт өгсөн байна.

3.3 Буддын шашны хийд, дацан, төв нь Монголын Бурхан шашинтны төвөөс батлан гаргасан стандарт, журмуудыг мөрдсөн байна.

3.4 Шашны байгууллага байгуулах хүсэлт гаргасан иргэний шаардагдах бичиг баримт бүрдэл болсон эсэх, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийн 8 дахь заалтын дагуу тухайн нутаг дэвсгэрт уг сүм, хийд цуглаан шаардлагатай эсэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөлөөс хянан үзэж газар дээр нь шалгаад санал дүгнэлтээ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлнэ.

3.5 Шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацааг сунгах тухай асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.6 Сүм хийд, шашны байгууллага нь үйл ажиллагаагаа зогсоохоор өөрөө шийдвэрлэвэл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс зохих шийдвэр гаргана.

3.7 Зөвшөөрлийг 1 /нэг/ жилийн хугацаатай олгоно.

Дөрөв.Хугацаа сунгах

4.1 Шашны байгууллага сүм хийдийн зөвшөөрлийн хугацааг сунгуулахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

а/Хугацаа сунгахыг хүссэн өргөдөл

б/Тухайн зөвшөөрлийн хугацаанд хийгдсэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аймгийн татварын байгууллагын тодорхойлолт

в/Үйл ажиллагааны талаар тухайн багийн Засаг даргын тодорхойлолт

4.2. Явуулсан үйл ажиллагаа, хийгдсэн ажлууд, шүтэн бишрэгчид итгэгчдийн тоо болон бусад асуудлыг хэлэлцэн зөвшөөрлийг 1-3 жилийн хугацаагаар сунгаж болно.

ав. Хяналт тавих

5.1 Зөвшөөрөл авсан сүм хийдийн хурал, цугларалтын үйл ажиллагаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөл болон Тэргүүлэгчдээс хяналт тавьж ажиллана.

5.2 Зөвшөөрөл авсан шашны байгууллага нь анхны батлагдсан дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах үйл ажиллагаанд чиглэл, байршил, удирдах бүрэлдэхүүн, ахлагч нь өөрчлөгдсөн тохиолдолд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд тухай бүр албан ёсоор мэдэгдэнэ.

5.3 Шашны байгууллага нь гэм, санваартан шүтэн бишрэгчдийн тоо, тухайн жилд хийсэн ажлын товч тайлан, танилцуулгыг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлнэ.

5.4 Монгол Улсын тусгаар тогтнол үндэсний аюулгүй байдал, иргэдийн зан заншил, үндэсний онцлогт харширсан аливаа үйл ажиллагаа явуулсан нь батлагдвал тухайн шашны байгууллагын үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авч, шаардлагатай бол хуулийн байгууллагад шилжүүлнэ.

5.5 Сүм, хийд аливаа шашны байгууллагын талаар иргэдээс ирүүлсэн санал гомдол, хүсэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Шашны асуудал эрхэлсэн зөвлөл хүлээн авч зохих журмын дагуу барагдуулна.

5.6 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс аливаа шашны байгууллагын үйл ажиллагааг зогсоосон тухай шийдвэр гармагц татварын болон цагдаагийн байгууллагад албан ёсоор мэдэгдэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

Зургаа. Шашны үйл ажиллагаанд хориглох зүйл

6.1. Шашны байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас гадуур өөр чиглэлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

6.2. Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, энэхүү журмын заалтыг зөрчсөн тохиолдолд зөвшөөрлийн хугацааг цуцлан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 03-ны
өдрийн 07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ ШАШНЫ
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлогын
хорооны дарга

Гишүүд: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Олон нийттэй харилцах
хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн
дарга

Баянхонгор аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга /зөвшилцснөөр/

_____оОо_____